

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	12
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	14
3.Аудитын тайлан .....	15
3.1. Ерөнхий зүйл .....	15
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	15
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт .....	15
3.4. Материаллаг байдал.....	16
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	16
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	17
3.7. Шилэн дансны мэдээлэл .....	19
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	19
3.9. Аудитын илрүүлэлт .....	19
<b>Залруулсан алдаа .....</b>	<b>19</b>
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .....	19
Аудитын зөвлөмж.....	22
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	22
4. Менежментийн захидал .....	23
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	27



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2021.02.25 № 04/538  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын санал дүгнэлт

#### Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол Солонгосын Политехник коллежийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар сөрөг дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлийн мэдэгдэхүйц нөлөөллийн улмаас Монгол Солонгосын Политехник коллежийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаатай, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулаагүй байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Монгол Солонгосын Политехник коллежийн 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн биелэлт нь нийт 8 зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн хөтөлбөр, тэдгээрийн гүйцэтгэлийг хангах 23 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс хэрэгжилт 97.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### Аудитын гол асуудал

Тус байгууллага нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан хугацаанд санхүүгийн тайланг аудитын байгууллагад хүргүүлээгүй, аудитын явцад санхүүгийн баримт материалыг зохих хугацаанд гаргаж ирүүлээгүй ба аудитаар илэрсэн дараах зөрчлүүдийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөө материаллаг бөгөөд түгээмэл тархалттай байна. Үүнд:

- Оюутны байрны төлбөрийг бэлнээр хүлээн авдаг, 20,530.0 мянган төгрөгийн орлогыг тухай бүрд нь харилцахад төвлөрүүлдэггүй.
- Байгууллагаас авах авлага 15,397.9 мянган төгрөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй.
- Цалингийн сүлжээ, шатлалыг баримтлаагүйгээс 1,017.1 мянган төгрөгийн цалин илүү олгосон, нийгмийн даатгалын болон татварын тооцооллын буруугаас 2,003.8 мянган төгрөг дутуу суутгасныг байгууллагын төсвөөс төлсөн.
- Оюутаны сургалтын төлбөрөөс урьдчилж орсон орлогоор бүртгэснийг тайлант хугацаанд хүлээн зөвшөөрөөгүй авлага бууруулж, тайланг буруу илэрхийлсэн.
- Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа, төсвийн зарцуулалтад тавих дотоод хяналтын тогтолцоо байхгүй зэрэг нь санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд материаллаг нөлөө үзүүлэхүйц байна.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан аудитын сөрөг дүгнэлтийн суурь болоход хангалттай бөгөөд зохистой гэдэгт итгэж байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой. Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дуусгавар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>641,133,455.29</u></b>	<b><u>585,058,654.76</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	00.00	00.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	150,839,500.00	235,670,806.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	150,839,500.00	235,670,806.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	25,397,920.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	150,839,500.00	210,272,886.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	490,293,955.29	349,387,848.76
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	361,346,938.50	226,417,779.00
35110	Тусгай зориулалттай материал	361,294,718.50	226,314,229.00
35130	Эм боох материал	52,220.00	103,550.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	128,947,016.79	122,970,069.76
35410	Бичиг хэргийн материал	4,198,515.00	2,099,035.00
35420	Аж ахуйн материал	123,899,701.79	115,969,580.26
35430	Сэлбэг хэрэгсэл	108,800.00	00.00
35450	Барилгын засварын материал	740,000.00	740,000.00
35470	Бусад хангамжийн материал	00.00	4,161,454.50
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>13,176,307,046.03</u></b>	<b><u>12,157,458,700.66</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	13,176,307,046.03	12,157,458,700.66
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	12,577,101,679.10	11,561,703,333.73
39201	Барилга, байгууламж, орон сууц	10,896,748,987.00	10,899,448,987.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(450,281,790.97)	(730,849,843.69)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	210,112,411.70	210,112,411.70
39204	Хуримтлагдсан элэгдэл	(119,710,448.00)	(145,173,585.80)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	4,124,895,469.21	3,887,003,407.15
39206	Хуримтлагдсан элэгдэл	(2,784,499,939.89)	(3,153,449,999.64)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	776,616,908.51	797,754,125.62
39208	Хуримтлагдсан элэгдэл	(403,238,924.56)	(503,333,046.95)
39209	Зам, гүүрийн байгууламж	304,667,000.86	304,667,000.86
39210	Хуримтлагдсан элэгдэл	(29,445,877.76)	(56,775,955.52)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,590,668.28	1,590,668.28
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,590,668.28)	(1,590,668.28)
39217	Ном	51,237,883.00	52,299,833.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	599,205,366.93	595,755,366.93
39301	Програм хангамж	25,650,000.00	25,650,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(13,008,333.07)	(16,458,333.07)
39303	Бусад биет бус хөрөнгө	586,563,700.00	586,563,700.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>13,817,440,501.32</u></b>	<b><u>12,742,517,355.42</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>4,590,500.00</u></b>

<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	00.00	4,590,500.00
<b>414</b>	<b>Урьдчилж орсон орлого</b>	00.00	4,590,500.00
41420	Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого	00.00	4,590,500.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>13,817,440,501.32</u></b>	<b><u>12,737,926,855.42</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	13,817,440,501.32	12,737,926,855.42
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,790,616,010.16	1,790,616,010.16
51101	Өмч: - төрийн	1,790,616,010.16	1,790,616,010.16
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	7,104,963,491.68	6,025,449,845.78
51210	Өмнөх үеийн үр дүн	7,104,963,491.68	7,104,963,491.68
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	(1,079,513,645.90)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,921,860,999.48	4,921,860,999.48
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>13,817,440,501.32</u></b>	<b><u>12,742,517,355.42</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дуусгавар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,220,775,860.00	3,422,691,872.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	602,628,160.00	291,581,772.50
120	Нийтлэг татварын бус орлого	602,628,160.00	291,581,772.50
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	602,628,160.00	291,581,772.50
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	314,237,280.00	182,137,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	21,580,150.00	20,470,000.00
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	-	58,768,772.50
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	266,810,730.00	30,206,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,618,147,700.00	3,131,110,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,410,148,700.00	3,078,841,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,410,148,700.00	3,078,841,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	52,269,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	-	52,269,000.00
1330	Төсвийн захирагчдаас	207,999,000.00	-
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	207,999,000.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	3,887,181,866.94	4,502,205,518.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,887,181,866.94	4,419,156,660.53
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,728,268,549.84	4,150,928,123.20
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,736,197,261.75	2,167,161,428.11
210101	Цалин	1,703,007,748.75	1,830,033,923.04
210102	Нэмэгдэл цалин	-	220,783,995.07
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,498,253.00	69,162,000.00
210104	Урамшуулал	26,691,260.00	47,181,510.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	220,059,096.29	276,678,075.04
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	163,776,057.30	231,092,502.68
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	14,522,114.25	14,588,309.43
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	12,610,089.68	9,345,107.77
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	3,148,869.91	2,650,196.29
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	26,001,965.16	19,001,958.87
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	175,139,959.08	135,208,684.03
210301	Гэрэл цахилгааны зардал	58,802,674.51	58,823,739.00
210302	Түлш, халаалтын зардал	76,414,619.45	41,486,465.32
210303	Цэвэр, бохир усны зардал	39,922,665.12	34,898,479.71
2104	Хангамж, бараа материалын зардал	79,908,636.30	99,951,370.14
210401	Бичиг хэргийн материал	1,103,950.00	3,888,540.00
210402	Тээвэр, шатахууны зардал	9,492,000.00	6,090,000.00
210403	Шуудан холбоо интернетийн төлбөр	16,148,324.30	15,958,253.14
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	4,760,000.00	12,962,940.00
210406	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	48,404,362.00	61,051,637.00
2105	Нормативт зардал	128,569,845.00	111,465,070.00



Монгол Солонгосын политехник коллежийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210501	Эм	970,640.00	548,170.00
210502	Хоол	126,608,605.00	108,869,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	990,600.00	2,047,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	70,322,900.00	34,521,411.61
210601	Багаж хэрэгсэл	-	144,100.00
210602	Тавилга	0.00	2,211,761.61
210604	Урсгал засвар	70,322,900.00	32,165,550.00
2107	Томилолт, зочны зардал	2,524,500.00	-
210702	Дотоод томилолтын зардал	2,524,500.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	78,411,130.00	67,405,424.53
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	70,602,900.00	59,992,000.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	4,600,000.00	4,600,000.00
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	441,504.00	889,320.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	645,026.00	359,312.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	44,000.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	2,099,700.00	1,520,792.53
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,237,135,221.42	1,258,536,659.74
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	273,000.00	-
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	228,378,524.00	228,077,111.03
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,008,483,697.42	1,030,459,548.71
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	158,913,317.10	268,228,537.33
2132	Бусад урсгал шилжүүлэг	80,464,521.00	196,871,912.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	64,322,100.00	151,576,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	6,352,000.00	37,762,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	9,790,421.00	7,533,412.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	68,877,890.58	71,356,625.33
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	68,877,890.58	71,356,625.33
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт	9,570,905.52	-
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн	9,570,905.52	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	83,048,857.87
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	83,048,857.87
222001	Тоног төхөөрөмж	0.00	83,048,857.87
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	(666,406,006.94)	(1,079,513,645.90)
5	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	(666,406,006.94)	(1,079,513,645.90)

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дуусгавар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	/төгрөгөөр/
			Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,935,425,630.00	3,279,721,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	317,277,930.00	148,611,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	317,277,930.00	148,611,500.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	184,977,930.00	148,611,500.00
120004 1	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	163,397,780.00	128,141,500.00
120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	21,580,150.00	20,470,000.00
120009	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	132,300,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,618,147,700.00	3,131,110,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,410,148,700.00	3,078,841,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,410,148,700.00	3,078,841,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	52,269,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	-	52,269,000.00
1330	Төсвийн захирагчдаас	207,999,000.00	-
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	207,999,000.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	2,934,215,630.00	3,250,846,977.18
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,934,215,630.00	3,250,846,977.18
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,785,590,558.42	2,982,618,439.85
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,740,169,504.30	2,171,625,877.18
210101	Үндсэн цалин	1,277,738,969.49	1,624,413,322.79
210102	Нэмэгдэл	294,046,392.81	489,169,415.30
210103	Унаа хоолны хөнгөлөлт	55,492,320.00	23,866,895.18
210104	Үр дүнгийн урамшуулал	112,891,822.00	34,176,243.91
2102	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	216,804,193.74	273,068,512.97
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	177,439,403.09	225,189,789.65
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	27,545,966.01	47,878,723.32
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,668,014.13	-
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	1,759,003.28	-
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	7,391,807.23	-
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	175,139,959.08	145,208,684.03
210301	Гэрэл цахилгааны зардал	58,802,674.51	77,834,379.32
210302	Түлш, халаалтын зардал	76,414,619.45	32,475,825.00
210303	Цэвэр, бохир усны зардал	39,922,665.12	34,898,479.71
2104	Хангамж, бараа материалын зардал	64,474,166.30	78,481,978.73
210401	Бичиг хэрэг	7,005,150.00	5,847,590.00
210402	Тээвэр, шатахуун	9,492,000.00	6,093,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	16,148,324.30	15,667,010.73
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,760,000.00	18,542,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	27,068,692.00	32,332,278.00
2105	Нормативт зардал	134,800,805.00	130,822,900.00

Монгол Солонгосын политехник коллежийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	890,000.00	599,500.00
210502	Хоол, хүнс	126,608,605.00	108,869,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,302,200.00	21,354,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	205,174,300.00	38,009,150.00
210601	Багаж техник хэрэгсэл	660,000.00	5,426,100.00
210604	Урсгал засвар	204,514,300.00	32,583,050.00
2107	Томилолт, зочны зардал	2,524,500.00	-
210702	Дотоод албан томилолт	2,524,500.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	78,411,130.00	67,696,666.94
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	70,602,900.00	59,992,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,600,000.00	4,600,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	441,504.00	889,320.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	645,026.00	359,312.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,099,700.00	1,812,034.94
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	168,092,000.00	77,704,670.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	168,092,000.00	77,704,670.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	148,625,071.58	268,228,537.33
2132	Бусад урсгал шилжүүлэг	79,747,181.00	196,871,912.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	64,322,100.00	151,576,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	6,352,000.00	37,762,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	9,073,081.00	7,533,412.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	68,877,890.58	71,356,625.33
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	68,877,890.58	71,356,625.33
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,210,000.00	28,874,622.82
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,210,000.00	28,874,622.82
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,210,000.00	28,874,622.82
2200	Дотоод эх үүсвэрээр	1,210,000.00	28,874,622.82
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,210,000.00	28,874,622.82
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(1,210,000.00)	(28,874,622.82)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	(0.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дуусгавар болсон тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/төгрөгөөр/ Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	1,790,616,010.16	4,972,640,620.90	7,720,589,877.20	<b>14,483,846,508.26</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	25,389,810.71	<b>25,389,810.71</b>
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,790,616,010.16</b>	<b>4,972,640,620.90</b>	<b>7,745,979,687.91</b>	<b>14,509,236,318.97</b>
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	(666,406,006.94)	<b>(666,406,006.94)</b>
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,790,616,010.16</b>	<b>4,921,860,999.48</b>	<b>7,104,963,491.68</b>	<b>13,817,440,501.32</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	<b>00.00</b>
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,790,616,010.16</b>	<b>4,921,860,999.48</b>	<b>7,104,963,491.68</b>	<b>13,817,440,501.32</b>
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	(1,079,513,645.90)	<b>(1,079,513,645.90)</b>
<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,790,616,010.16</b>	<b>4,921,860,999.48</b>	<b>6,025,449,845.78</b>	<b>12,737,926,855.42</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дуусгавар болсон тайлан

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	/төгрөгөөр/	
				Дүн	Хувь
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,171,841,100.00	3,109,749,424.67	62,091,675.33	98.04
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	3,171,841,100.00	3,109,749,424.67	62,091,675.33	98.04
210	Бараа, үйлчилгээний зардал	2,979,940,100.00	2,917,877,512.67	62,062,587.33	97.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,151,627,500.00	2,151,625,877.18	1,622.82	100.00
210101	Үндсэн цалин	1,334,034,500.00	1,604,413,322.79	(270,378,822.79)	120.27
210102	Нэмэгдэл	613,368,100.00	489,169,415.30	124,198,684.70	79.75
210103	Унаа, болон бусад нөхөн олговор	76,230,000.00	23,866,895.18	52,363,104.82	31.31
210104	Урамшуулал	127,994,900.00	34,176,243.91	93,818,656.09	26.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	290,469,800.00	273,068,512.97	17,401,287.03	94.01
210201	Тэтгэврийн даатгал	204,404,600.00	225,189,789.65	(20,785,189.65)	110.17
210202	Тэтгэмжийн даатгал	21,516,300.00	47,878,723.32	(26,362,423.32)	222.52
210203	ҮОМШӨ ний даатгал	17,213,000.00	-	17,213,000.00	-
210204	Ажилгүйдлийн даатгал	4,303,300.00	-	4,303,300.00	-
210205	Эрүүл мэндийн даатгал	43,032,600.00	-	43,032,600.00	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	161,802,500.00	145,208,684.03	16,593,815.97	89.74
210301	Гэрэл цахилгаан	66,590,100.00	77,834,379.32	(11,244,279.32)	116.89
210302	Түлш, халаалт	59,500,900.00	32,475,825.00	27,025,075.00	54.58
210303	Цэвэр, бохир ус	35,711,500.00	34,898,479.71	813,020.29	97.72
2104	Хангамж, бараа материалын зардал	81,652,500.00	68,332,419.73	13,320,080.27	83.69
210401	Бичиг хэрэг	5,968,400.00	5,847,590.00	120,810.00	97.98
210402	Тээвэр (шатахуун)	22,713,100.00	6,093,100.00	16,620,000.00	26.83
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	14,627,600.00	14,545,010.73	82,589.27	99.44
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	18,542,000.00	18,542,000.00	-	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	19,801,400.00	23,304,719.00	(3,503,319.00)	117.69
2105	Нормативт зардал	115,534,000.00	113,119,900.00	2,414,100.00	97.91
210501	Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	660,500.00	599,500.00	61,000.00	90.76
210502	Хоол, хүнс	111,222,100.00	108,869,100.00	2,353,000.00	97.88
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	3,651,400.00	3,651,300.00	100.00	100.00
2106	Эд хогшил худалдан авах	21,389,000.00	21,120,781.82	268,218.18	98.75
210601	Багаж, техник, хэрэгсэл	823,000.00	562,281.82	260,718.18	68.32
210604	Урсгал засвар	20,566,000.00	20,558,500.00	7,500.00	99.96
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	67,886,700.00	67,696,666.94	190,033.06	99.72
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	59,992,000.00	59,992,000.00	-	100.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	4,600,000.00	4,600,000.00	-	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	990,000.00	889,320.00	100,680.00	89.83
210804	Тээврийн хэрэгслийн татвар	370,900.00	359,312.00	11,588.00	96.88

Монгол Солонгосын политехник коллежийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	118,800.00	44,000.00	74,800.00	37.04
210806	Мэдээллийн технологийн зардал	1,815,000.00	1,812,034.94	2,965.06	99.84
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	89,578,100.00	77,704,670.00	11,873,430.00	86.75
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	89,578,100.00	77,704,670.00	11,873,430.00	86.75
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	191,901,000.00	191,871,912.00	29,088.00	99.98
2132	Бусад урсгал шилжүүлэг	191,901,000.00	191,871,912.00	29,088.00	99.98
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	151,576,200.00	151,576,200.00	-	100.00
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	37,762,300.00	37,762,300.00	-	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	2,562,500.00	2,533,412.00	29,088.00	98.86
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,171,841,100.00	3,109,749,424.67	52,996,675.33	98.04
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,078,841,100.00	3,016,749,424.67	62,091,675.33	97.69
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,078,841,100.00	3,016,749,424.67	62,091,675.33	97.69
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	93,000,000.00	102,095,000.00	(9,095,000.00)	109.78
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	85,000,000.00	85,000,000.00	-	100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,000,000.00	17,095,000.00	(9,095,000.00)	213.69
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	(0.00)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	0.00	(0.00)	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	141	141	-	100.00
620001	Удирдах ажилтан	3	3	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	99	99	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	39	39	-	100.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/	-	-	-	-
64	ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО	-	-	-	-

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дуусгавар болсон тайлан

			/төгрөгөөр/
ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		98,785,500.00
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН		98,785,500.00
210	Бараа, үйлчилгээний зардал		93,615,550.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		20,000,000.00
210101	Үндсэн цалин		20,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		12,206,000.00
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр		1,122,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс		11,084,000.00
2105	Нормативт зардал		17,703,000.00
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл		17,703,000.00
2106	Эд хогшил худалдан авах		43,706,550.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		5,282,000.00
210602	Тавилга		26,400,000.00
210604	Урсгал засвар		12,024,550.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		5,169,950.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		5,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал		5,000,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		169,950.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		169,950.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		98,785,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		98,785,500.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		52,269,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		46,516,500.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-



### **3.Аудитын тайлан**

---

#### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Солонгосын политехник коллежийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг захирал Ц.Ганчимэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, батлагдсан төсвийн хуваарийг баталгаажуулан авч мөрдөж ажиллах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 30-наас 2021 оны 02 дугаар сарын 22–ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг Үндэсний аудитын газрын захиалгаар “Амгалан ахуй Аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Монгол Солонгосын политехник коллежийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Амгалан ахуй аудит” ХХК-д 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 01/15 дугаар бүхий албан бичгээр 2021 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр ирүүлсэн байна.

#### **3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Монгол Солонгосын политехник коллежийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Дэлхийн хөгжлийн ерөнхий хандлага, Монгол орны эдийн засаг, нийгмийн хэрэгцээ шаардлагыг хангах, зах зээлийн эдийн засгийн харилцаанд өрсөлдөх, хөрвөх чадвар бүхий хүмүүнлэг ардчилсан нийгмийн харилцаанд төлөвшсөн мэргэжилтэн бэлтгэх, нийгмийн үйлчилгээний орчин бүрдүүлж иргэдэд үйлчлэхэд оршино” гэжээ.

Монгол Солонгосын политехник коллежийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Мэргэжил эзэмшүүлэх, техникийн боловсрол олгох сургалтын үйл ажиллагаа явуулах,
- Захиалгат болон насанд хүрэгчдэд мэргэжил олгох сургалт.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна.

#### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Монгол Солонгосын политехник коллеж санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.



Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь байгууллагын үйл ажиллагааны чиглэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцүүлэн шинэчлээгүй байна.

Монгол Солонгосын политехник коллеж санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангаж ашигладаг байна. Мөн цалингийн нэгдсэн сүлжээнд холбогдсон болно.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд байгууллага нь батлагдсан төсвийн дагуу зарцуулалт гаргадаг ба төсвийн орлого бүрдүүлдэг байгууллага биш гэдгийг үндэслэн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны эхний хагас жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,220,696.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 22,207.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны нийт зардлыг сонгож 4,448,598.7 мянган төгрөгийн 1.0 хувиар тооцон 44,486.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Монгол Солонгосын политехник коллежийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,046,320.4 мянган төгрөгөөр буюу 7.6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	150,839.5	235,670.8	84,831.3
Урьдчилгаа			0.0
Бараа материал	490,294.0	349,387.8	(140,906.2)
Үндсэн хөрөнгө	13,176,307.0	12,157,458.7	(1,018,848.3)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>13,817,440.5</b>	<b>12,742,517.4</b>	<b>(1,074,923.1)</b>
Өр төлбөр		4,590.5	4,590.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	13,817,440.5	12,737,926.9	(1,079,513.7)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>13,817,440.5</b>	<b>12,742,517.4</b>	<b>(1,074,923.1)</b>

Авлагын дансны үлдэгдэл 235,670.8 мянган төгрөг болж 84,831.3 мянган төгрөгөөр өссөн нь Дэлхий нийтийг хамарсан цар тахлын улмаас хичээл сургалт явагдаагүй, оюутнуудын сургалтын төлбөрийн үлдэгдэл нэмэгдсэн, харилцагч байгууллагад хичээл үйлдвэрлэлийн дадлагын материалын урьдчилгаа төлбөр шилжүүлсэнтэй холбоотой байна. Авлага дансны үлдэгдэл нь 2019 оноос эхлэн

үүссэн байна. Авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нягтлан бодох бүртгэлд тусгасан байгаа нь найдваргүй авлагын нөөц үүсэх эрсдэлтэй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 349,387.8 мянган төгрөг болж 140,906.1 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онд тусгай зориулалтын материалд 152,000.0 мянган төгрөгийн төсөвтэй байсныг тайлант онд 89,578.1 мянган төгрөг болгож бууруулж батлагдсанаас хичээл үйлдвэрлэлийн материалын татан авалт тайлант хугацаанд бүрэн хийгдээгүйгээс авлага үүссэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 12,157,458.7 мянган төгрөг болж 1,018,848.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант жилийн элэгдлийн зардал болон Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэрээр акталсан хөрөнгөтэй холбоотой. Үндсэн хөрөнгийн данс нь хөрөнгө оруулалтаар 33,781.2 мянган төгрөг, урсгал төсвийн худалдан авалтаар 32,884.6 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүйгээр 30,206.0 мянган төгрөгийн машин, тоног төхөөрөмж, эд хогшил, номоор нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө акталсан 83,048.9 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 4,590.5 мянган төгрөг болж өссөн нь сургалтын төлбөр урьдчилж орсон орлогоос шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 12,737,926.9 мянган төгрөг болж 1,074,923.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Монгол Солонгосын политехник коллежийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 202,316.0 мянган төгрөгөөр буюу 1.1 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь улсын төсвийн санхүүжилт 668,691.4 мянган төгрөгөөр өссөн хэдий ч үндсэн үйл ажиллагааны болон туслах үйл ажиллагааны орлого өмнөх онтой харьцуулахад 132,810.4 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь тайлант онд ковид-19 цар тахлын улмаас суралцагчдын болон түрээслэгчдийн тоо буурсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 616,271.0 мянган төгрөгөөр буюу 15.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь цалин хөлс, тэтгэмж 432,211.6 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 56,617.0 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардал 20,042.7 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлууд 21,410.4 мянган төгрөг байна. Цалин хөлс, тэтгэмжийн зардал нэмэгдсэн шалтгаан нь 5 жил тутамд олгох тэтгэмж, шүүхийн шийдвэрээр олгосон нөхөн олговор, амны хаалт оёсон ажлын хөлс олгосон зэргээс болсон байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 4,392,161.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 1,106,536.4 мянган төгрөгөөр бууруулж, 3,285,624.7 мянган төгрөгийн санхүүжилт баталсан байна.

Тайлант онд батлагдсан төсвөөс 62,091.7 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн нь төсвийн шууд захирагч төсвийн төслийг бодитой боловсруулдаггүй байна.

### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн 23 арга хэмжээг санхүүжүүлэхээр нийт 3,171,841.1 мянган төгрөгийн төсөв баталснаас 3,078,841.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, 93,000.0 мянган төгрөгийг үндсэн ба туслах үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,078,841.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 102,095.0 мянган төгрөг, нийт 3,180,936.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 3,109,749.4 мянган төгрөгийг зарцуулж 62,091.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,109,749.4 мянган төгрөг буюу 98 хувьтай байгаа нь ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 17,401.3 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 16,593.8 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 13,320.1 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 11,873.4 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Байр ашиглалт, хангамж, бараа материалын зардлын хэмнэлт нь Ковид-19 цар тахлын улмаас хичээл сургалтын үйл ажиллагаа зогссонтой холбоотойгоор хэмнэгдсэн.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн сайдын 2020 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 225 тоот тушаалаар давсан орлогоос 46,516.5 мянган төгрөгийг зарцуулах эрх, “Койка” Олон улсын байгууллага, “Германы хамтын ажиллагааны сан” зэрэг төрийн бус байгууллагуудаас 52,269.0 мянга төгрөг хандивын орлого бүрдүүлж нийт 98,785.5 мянга төгрөгийг нэмэлт санхүүжилтийн данснаас зарцуулах эрх авсан.

Үүнээс цалин хөлсний зардалд 20,000.0 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардалд 12,206.0 мянган төгрөг, нормативт зардалд 17,703.0 мянган төгрөг, эд хогшил худалдан авах 43,706.5 мянган төгрөг бусад урсгал шилжүүлэгт 5,000.0 мянган төгрөг нийт 98,615.2 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 170.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 148 мэдээллээс хугацаандаа оруулсан 104 мэдээлэл, хугацаа болоогүй 3 мэдээлэл, хугацаа хоцроосон 41 мэдээлэл, таван сая төгрөгөөс дээш зарлагаас худалдан авалтын 246,514.8 мянган төгрөгийн 15 мэдээллийг байршуулаагүй байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 24,564.5 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 17,426.3 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгснөөс албан шаардлага бүрэн хэрэгжиж, 1 зөвлөмж хэрэгжээгүй буюу хэрэгжилт 48 хувьтай байна.

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 560,444.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 99,458.3 мянган төгрөгийн алдааг залруулж, 3,183.9 мянган төгрөгийн зөрчилд 4 акт тогтоож, 293,332.7 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, 164,469.4 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 7 зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Тайлант оны нийт сургалтын төлбөрийн 20,413.6 мянган төгрөгийн дутуу тайлагнасан орлогыг залруулсан.
2. Үндсэн үйл ажиллагааны орлого бууруулж тайлагнасан 4.103.8 мянган төгрөгийн зарцуулалтыг залруулж холбогдох зардалд бүртгэсэн.
3. Тайлант хугацаанд 1 ажилтанд 847.4 мянган төгрөгийн цалингийн урьдчилгаа олгож зардалд тусгасныг залруулж, урьдчилгаагаар бүртгүүлсэн.
4. Хөрөнгийн элэгдэл тооцох хугацааг хасах утгатай, зарим хөрөнгийн элэгдлийн зардлыг дутуу тооцсон нийт 59,503.0 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг залруулсан.
5. Сургалтын төлбөрийн 4,590.5 мянган төгрөгийн урьдчилж орсон орлогыг тус дансанд бүртгээгүй авлага дансыг бууруулж тайлагнасныг залруулав.
6. 2020 оны 12 дугаарын сарын цахилгааны төлбөрийг 10,000.0 мянган төгрөгөөр илүү шилжүүлж зардалд бүртгэснийг авлагаар бүртгэж залруулав.

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 296,516.6 мянган төгрөгийн залруулаагүй алдаа, зөрчлөөс илэрснээс 3,183.9 мянган төгрөгийн зөрчилд 4 акт тогтоож, 293,332.7 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Элсэгчдээс авдаг "Бүртгэлийн хураамж"-ийн 5,960.0 мянган төгрөгийн орлогыг санхүүгийн тайланд тусгаагүй зарцуулсан байна. Үүнээс баримтаар нотлогдохгүй 163.0 мянган төгрөгийн зарцуулалт байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т *“төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”*, 6 дугаар зүйлийн 6.3.1-д *“төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн*

*гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах*” гэсэн заалтуудтай нийцээгүй, иж бүрэн, үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

2. Зарим ажилчдын цалингаас нийт 1,263.5 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл суутгаагүй олгосон ба нийгмийн даатгалын тайлангийн ажилтны төлөх шимтгэлийг байгууллагаас төлсөн байгаа нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2-т *“Нийгмийн даатгалд дор дурьдсан ажилтан албан журмаар даатгуулна”*, 15 дугаар зүйлийн 1-т *“Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2, 4 дэх хэсэгт заасан даатгуулагч болон ажил олгогч нь дор дурдсан хувь хэмжээгээр сар бүр нийгмийн даатгалын шимтгэл төлнө”*, мөн хуулийн 16 дугаар зүйлийн 1-т *“Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагчийн болон ажил олгогчийн тухайн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийг нийгмийн даатгалын төрөл бүрээр энэ хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувь хэмжээгээр сар бүр тооцож, тухайн сард нь багтаан нийгмийн даатгалын сангийн дансанд шилжүүлнэ”* гэсэн заалтуудтай нийцээгүй, иж бүрэн байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

3. Зарим ажилчдын цалингаас 740.3 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг суутгаагүй олгож татварыг байгууллагаас төлсөн нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7.1 *“Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлогыг хамруулна ... үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого”* болон 14.1-д *“Энэ хуулийн 7.1-д заасан цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо уг орлогоос эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд төлсөн шимтгэлийг хасна”* гэж заасныг хэрэгжүүлээгүй, иж бүрэн байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

4. ЗГ-ын тогтоолоор батласан цалингийн сүлжээ, шатлалыг баримтлаагүй 1,017.1 мянган төгрөгийн илүү цалин олгосон байна. Энэ нь Засгийн газрын 2019 оны 472 дугаар *“Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох”* тухай тогтоолын 6 дугаар хавсралт *“Мэргэжлийн боловсрол олгох сургуулийн төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн сүлжээ”*-г хэрэгжүүлээгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

5. Өмнөх аудитын зөвлөмжөөр анхан шатны баримт дутуу, батлагдсан төсөвгүй зарцуулсан 3,830.7 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-т *“аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд*



*аудитор*т үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх” гэсэн заалттай нийцээгүй, үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

6. Шүүхийн шийдвэрээр ажлаас хууль бусаар халсан нь тогтоогдсон нэр бүхий 2 ажилтанд 24,112.0 мянган төгрөгийн нөхөн олговрыг байгууллагаас олгосныг буруу шийдвэр гаргасан албан тушаалтнаар төлүүлээгүй байна. Энэ нь Монгол Улсын Иргэний тухай хуулийн 498 дугаар зүйлийн 498.5-д “Энэ хуулийн 498.1, 498.2, 498.4-т заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй”, Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн, 103.1-д “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ”, Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1-д “Төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ” гэсэн заалтуудтай нийцэхгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

7. Байгууллага тайланд онд шилэн дансны цахим хуудсанд байршуулах 114 мэдээлэлээс 41 мэдээлэл хугацаа хоцроосон мөн 5 сая төгрөгөөс дээш худалдан авалтын 246,514.8 мянган төгрөгийн 15 мэдээллийг байршуулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, 6 дугаар зүйлийн 6.4 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ .... таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг” мөн хуулийн 3 дугаар зүйлийн 3.4 “Төрийн нууцад хамаарахаас бусад төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагналыг байгууллагын нууцад хамааруулан нийтэд мэдээлэхээс зайлсхийхийг хориглоно” гэсэн заалтуудтай нийцэхгүй, үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

8. Оюутнууд танхимаар хичээллээгүй хугацаанд хичээл үйлдвэрлэлийн дадлагад зориулагдсан 18,875.2 мянган төгрөгийн тусгай зориулалтын материалаас зарцуулсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар” –ын 6-д “Материалын үнэ бүхий зүйлсийг байгууллагын үйлдвэрлэл, дотоод хэрэгцээнд зарцуулах шаардлага гарсан үед уг зүйлийг авч зарцуулах хүн “Шаардах хуудас”-ыг 1 хувь үйлдэж зөвшөөрөл авна. Эд хариуцагч шаардах хуудсыг үндэслэн материал, үнэ бүхий зүйлийг тавьж олгосны дараа агуулахын бүртгэлд бичилт хийж, тайлант хугацаанд нягтлан бодогчид хүргүүлнэ”,

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 “жинхэнэ хэрэгжилтийн” 5.1.4 “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.1.1 “нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах” гэсэн заалтуудтай нийцээгүй, оршин байх, үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна. гэсэн заалтуудтай нийцээгүй, оршин байх, үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

### **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 164,469.4 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 7 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаатай холбоотой аудит хийх цар хүрээ хязгаарлагдаж, байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхэд хөрөнгийн биет тооллого хийх, цалин хөлсийг тушаал шийдвэрийн дагуу тулгах, төсвийн хяналтыг хэрэгжүүлсэн нөхцөл байдал зэргийг баталгаажуулахад хязгаарлагдмал байсан, дараагийн аудитаар бараа материал, үндсэн хөрөнгийн тооллогыг үр дүнтэй зохион байгуулсан эсэхийг тусгайлан авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

#### **4. Менежментийн захидал**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### *Санхүүгийн тайлангийн данстай холбоотой асуудал*

###### **1.1. Илрүүлэлт:**

Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгөнүүдийг бодит үнэ цэнээр нь үнэлээгүй нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7.1-д “Төрийн өмчийн хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэж Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэсэн заалттай нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

###### **1.2. Эрсдэл:**

Санхүүгийн байдлын тайланд үндсэн хөрөнгийн үнэлгээ бодитой илэрхийлэгдэхгүй байх

###### **1.3. Өгсөн зөвлөмж:**

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгөнүүдийг бодит үнэ цэнээр нь үнэлэх, ашиглагдах жилийг шинэчлэх талаар санал боловсруулж Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хандан шийдвэрлүүлэх.

###### **1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Өгсөн зөвлөмжийг биелүүлж ажиллах болно.

##### *Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаатай холбоотой асуудал:*

###### **2.1. Илрүүлэлт:**

Худалдан ажиллагаатай холбоотой тендерийн баримт материалыг хянан үзэхэд "Харуул хамгаалалт"-ын тендерийн үнэлгээний хорооны гишүүдийн АЗ сертификат байхгүй, "Хичээл үйлдвэрлэлийн материал"-ын тендерийн үнэлгээний хорооны хараат бус гишүүдийн АЗ сертификатын хүчинтэй хугацаа дуусгавар болсон байна. Мөн гэрээ байгуулах эрх олгосноос хойш ажлын 6-аас доошгүй хоногийн дараа гэрээ байгуулна гэсэн хуулийн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Дотоод хяналтын ажилтан санхүүгийн болон худалдан авах ажиллагааны тендерт биечлэн оролцсон байна. Энэ нь ТБОНӨХБАҮХТХ-ийн 47 дугаар зүйлийн 47.3 “Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд орсон албан тушаалтан дараахь шаардлагыг хангасан байвал зохино ... 47.3.1 “худалдан авах ажиллагааны чиглэлээр, эсхүл тухайн бараа, ажил, үйлчилгээнд холбогдох салбарт мэргэшсэн байх”, 29.2-т “Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдээгдсэнээс хойш ажлын 6-аас доошгүй хоногийн дараа, тендер хүчинтэй байх хугацаанд багтааж гэрээ байгуулна” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

###### **2.2. Эрсдэл:**

Хараат бус байдал алдагдах, мэргэжлийн бус шийдэл гаргах, дотоод хяналт сулрах, хуулийн хэрэгжүүлэхгүй байх.



**2.3. Өгсөн зөвлөмж:**

Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа хуулийг хэрэгжүүлж ажиллах.

**2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Тухай үеийн удирдлага өөрчлөгдсөн. Цаашид ийм алдаа гаргахгүй.

**3.1. Илрүүлэлт:**

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн шинэчлээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 18.2 “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**3.2. Эрсдэл:**

Нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагаа УСНББОУС болон байгууллагын онцлог, салбарын нягтлан бодох бүртгэлийн бодлоготой уялдахгүй байх.

**3.3. Өгсөн зөвлөмж:**

НБББББ-т сургалтын төлбөрийн бүртгэл, оюутны байрны төлбөр, элсэлтийн хураамжийн орлогыг бүртгэх талаар болон бусад байгууллагын онцлогт тааруулж шинэчлэн боловсруулах.

**3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Хөдөлмөр нийгэм хамгааллын яамнаас гаргасан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг харьяа байгууллагууд хэрэглэдэг.

*Дотоод хяналттай холбоотой*

**4.1. Илрүүлэлт:**

Тайлант хугацаанд сургалтын төлбөрийн 128,141.5 мянган төгрөгийн орлого хүлээн авсныг цахим төлбөрийн баримт олгоогүй байна. Энэ нь Төлбөрийн цахим баримтыг Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 347 дугаар тушаалаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын зааснаар "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. “Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QRкодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ”, Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалтуудтай нийцэхгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**4.2. Эрсдэл:**

Оюутнуудын төлбөрийн тооцоо тулгалтыг бүрэн баталгаажуулахгүй байх, хууль хэрэгжүүлэхгүй байх.

**4.3. Өгсөн зөвлөмж:**

Хууль, журмыг хэрэгжүүлж ажиллах, сургалтын төлбөрийн орлогыг тухай бүрт хянан баталгаажуулж, хэрэглэгчийн цахим системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх.

**4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Цахим төлбөрийн баримт олгодоггүй. Хувь хүний орлогын албан татварын буцаалт авахаар цахим төлбөрийн баримт авах оюутанд гаргаж өгдөг.

**5.1. Илрүүлэлт:**

Багш, ажиллагсадтай байрны гэрээ байгуулаагүй, 400.0 мянган төгрөгийн цалингаас суутгасан дотуур байрны төлбөрийг орлогоор бүртгээгүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т *“төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”*, 6 дугаар зүйлийн 6.3.1-д *“төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах”* гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

**5.2. Эрсдэл:**

Туслах үйл ажиллагааны орлого буруу бүртгэгдэх, ашиглан үүсэх.

**5.3. Өгсөн зөвлөмж:**

Хуулийг хэрэгжүүлж ажиллах, орлого, зардлыг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр тайлагнах.

**5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

**6.1. Илрүүлэлт:**

Байгууллагаас авах авлага 15,397.9 мянган төгрөгийг тооцоо нийлсэн акт үйлдэн баталгаажуулаагүй, гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д *“Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: ..... дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”* гэсэн заалттай нийцээгүй, иж бүрэн байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**6.2. Эрсдэл:**

Хуулийг хэрэгжүүлэхгүй байх, санхүүгийн тоон мэдээлэл буруу илэрхийлэгдэх.

**6.3. Өгсөн зөвлөмж:**

Тооцоо нийлсэн акт, гэрээ дүгнэсэн акт үйлдэн тооцоог гарахаас өмнө хянан баталгаажуулж байх.

**6.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

**7.1. Илрүүлэлт:**

Оюутны байрны төлбөр 20,530.0 мянган төгрөгийг жижиг мөнгөн санд тушаасныг мөнгөн кассын журам хэрэгжүүлж төсөвт байгууллагын харилцах дансанд холбогдох журмын дагуу тушаагаагүй байна. Кассад төвлөрүүлсэн бэлэн мөнгийг Сангийн сайдын 276 дугаар тушаалаар баталсан "Мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 3.12-т *“Эрх бүхий ажилтан хураасан орлогоо өөрийн байгууллагын бүртгэлийн дансанд ажлын 1 хоногт багтаан тушааж сар бүрийн эцэст зарагдсан тасалбарын бүртгэл болон орлого цуглуулсан баримтын тооцоог гаргаж тайланг тушаана”* гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**7.2. Эрсдэл:**

Хуулийг хэрэгжүүлэхгүй байх, залилан ба ашиглан гарах.

7.3. Өгсөн зөвлөмж:

Эрх бүхий ажилтан хураасан орлогоо өөрийн байгууллагын бүртгэлийн дансанд ажлын 1 хоногт багтаан тушааж сангийн сайдын журмыг хэрэгжүүлэн ажиллах.

7.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021.02.25	Аудитын нэр: Монгол Солонгосын политехникийн коллежийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: САГ-2021/311/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр: Монгол Солонгосын политехникийн коллеж		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5	
1	Элсэгчдээс авсан "Бүртгэлийн хураамж"-ийн орлого 5.6 сая төгрөгийг санхүүгийн тайланд тусгаагүй зарцуулсанаас баримтаар нотлогдохгүй зарцуулалт 163.0 мянган төгрөг байна.	163.0	Акт	Захирал Ахлах нягтлан бодогч	Ц.Ганчимэг П.Пүрэвдорж
2	Зарим ажиллагсдын цалингаас нийгмийн даатгалын шимтгэл суутгаагүй олгосон.	1,263.5	Акт	Захирал Ахлах нягтлан бодогч	Ц.Ганчимэг П.Пүрэвдорж
3	Зарим ажиллагсдын цалингаас хувь хүний орлогын албан татварыг суутгаагүй олгосон	740.3	Акт	Захирал Ахлах нягтлан бодогч	Ц.Ганчимэг П.Пүрэвдорж
4	Төрийн албаны цалингийн сүлжээ, шатлал баримтлаагүй илүү цалин олгосон байна.	1,017.1	Акт	Захирал Ахлах нягтлан бодогч	Ц.Ганчимэг П.Пүрэвдорж
5	Өмнөх аудитын зөвлөмжөөр анхан шатны баримт дутуу, батлагдсан төсөвгүй зарцуулсан зөрчлийг давтан гаргасан байна.	3,830.7	Албан шаардлага	Захирал Ахлах нягтлан бодогч	Ц.Ганчимэг П.Пүрэвдорж
6	Шүүхийн шийдвэрээр ажлаас хууль бусаар халсан нь тогтоогдсон нэр бүхий 3-н ажилтанд байгууллагаас тэтгэмжийг нь олгосон байна.	24,112.0	Албан шаардлага	Захирал Ахлах нягтлан бодогч	Ц.Ганчимэг П.Пүрэвдорж
7	Байгууллага тайланд онд нийт 41 мэдээлэл хугацаа хоцроосон мөн 5 сая төгрөгөөс дээш худалдан авалтын 15 мэдээллийг байршуулаагүй байна	246,514.8	Албан шаардлага	Захирал, Ахлах нягтлан бодогч	Ц.Ганчимэг, П.Пүрэвдорж
8	Оюутнууд танхимаар хичээллээгүй хугацаанд хичээл үйлдвэрлэлийн дадлагад зориулагдсан 18,875.2 мянган төгрөгийн тусгай зориулалтын материалаас зарцуулсан байна.	18,875.2	Албан шаардлага	Захирал Ахлах нягтлан бодогч	Ц.Ганчимэг П.Пүрэвдорж
9	Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийг бодит үнэ цэнээр нь үнэлэх,	-	Зөвлөмж	Захирал Ахлах нягтлан бодогч	Ц.Ганчимэг П.Пүрэвдорж

	ашиглагдах жилийг шинэчлэх талаар Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хандан шийдвэрлүүлээгүй байна.				
10	Худалдан ажиллагаатай холбоотой тендерийн баримт материалыг хянан үзэхэд "Харуул хамгаалалт"-ын тендерийн үнэлгээний хорооны гишүүдийн АЗ сертификат байхгүй, "Хичээл үйлдвэрлэлийн материал"-ын тендерийн үнэлгээний хорооны хараат бус гишүүдийн АЗ сертификатын хүчинтэй хугацаа дуусгавар болсон байна. Мөн гэрээ байгуулах эрх олгосноос хойш ажлын 6-аас доошгүй хоногийн дараа гэрээ байгуулна гэсэн хуулийн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Дотоод хяналтын ажилтан санхүүгийн болон худалдан авах ажиллагааны тендерт биечлэн оролцсон байна.	-	Зөвлөмж	Захирал Ахлах нягтлан бодогч	Ц.Ганчимэг П.Пүрэвдорж
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн шинэчлээгүй байна.	-	Зөвлөмж	Захирал Ахлах нягтлан бодогч	Ц.Ганчимэг П.Пүрэвдорж
12	Тайлант хугацаанд сургалтын төлбөрийн орлого хүлээн авсаныг цахим төлбөрийн баримт олгоогүй байна.	128,141.5	Зөвлөмж	Захирал Ахлах нягтлан бодогч	Ц.Ганчимэг П.Пүрэвдорж
13	Багш, ажиллагсадыг байранд оруулахад гэрээ байгуулаагүй, төлбөрийг жижиг мөнгөн санд хүлээн авсан, цалингаас дотуур байрны төлбөрийг суутгасаныг орлогоор бүртгээгүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	400.0	Зөвлөмж	Захирал Ахлах нягтлан бодогч	Ц.Ганчимэг П.Пүрэвдорж
14	Байгууллагаас авах авлагыг тооцоо нийлсэн акт үйлдэн баталгаажуулаагүй, гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй байна.	15,397.9	Зөвлөмж	Захирал Ахлах нягтлан бодогч	Ц.Ганчимэг П.Пүрэвдорж
15	Оюутны байрны төлбөр 20,530.0 мянган төгрөгийг жижиг мөнгөн санд тушаасныг мөнгөн кассын журам хэрэгжүүлж төсөвт байгууллагын харилцах дансанд холбогдох журмын дагуу тушаагаагүй байна.	20,530.0	Зөвлөмж	Захирал Ахлах нягтлан бодогч	Ц.Ганчимэг П.Пүрэвдорж
	<b>ДҮН</b>	<b>460,986.0</b>			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2021 оны 02 дугаар сарын 25

№ 34/АОН0047

Улаанбаатар хот

САГ-2021/311/СТР-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Монгол Солонгосын политехник коллежийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

ЗГ-ын тогтоолоор батласан цалингийн сүлжээ, шатлалыг баримтлалгүй нэр бүхий 5 ажилтанд 1,017,144.0 /нэг сая арван долоон мянга нэг зуун дөчин дөрөв/ төгрөгийн илүү цалин олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 472 дугаар "Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох" тухай тогтоолын 6 дугаар хавсралт "Мэргэжлийн боловсрол олгох сургуулийн төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн сүлжээ", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах," 16 дугаар зүйлийн 16.5.5. "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах," гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Нэр бүхий 5 ажилтанд илүү олгосон 1,017,144.0 /нэг сая арван долоон мянга нэг зуун дөчин дөрөв/ төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2021 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Солонгосын Политехник Коллежийн захирал Ц.Ганчимэг, ахлах нягтлан бодогч П.Пүрэвдорж нарт хариуцуулав.


**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТОР  
"АМГАЛАН АХУЙ АУДИТ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Г.ТҮВШИНЗАЯА  
Д.АМГАЛАН



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig\_Khereg\Akt\2021\0225auditin 2-R Gazar 31.Docx

001090478





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2021 оны 02 дугаар сарын 25

№ 35 / АДТН0011

Улаанбаатар хот

САГ- 2021/311/СТД-1Ш3

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Монгол Солонгосын политехник коллежийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Зарим ажилчдын цалингаас нийт 1,263,505.0 /нэг сая хоёр зуун жаран гурван мянга таван зуун тав/ төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг суутгаагүй олгож, ажилтны төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг байгууллагаас төлж төсвийн хөрөнгийг үндэслэлгүй илүү зарцуулсан байна.

Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2-т "Нийгмийн даатгалд дор дурьдсан ажилтан албан журмаар даатгуулна", 15 дугаар зүйлийн 15.1-т "Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2, 4 дэх хэсэгт заасан даатгуулагч болон ажил олгогч нь дор дурдсан хувь хэмжээгээр сар бүр нийгмийн даатгалын шимтгэл төлнө", хуулийн 16 дугаар зүйлийн 1-т "Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагчийн болон ажил олгогчийн тухайн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийг нийгмийн даатгалын төрөл бүрээр энэ хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувь хэмжээгээр сар бүр тооцож, тухайн сард нь багтаан нийгмийн даатгалын сангийн дансанд шилжүүлнэ" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Нийгмийн даатгалын шимтгэлийг суутган тооцож 1,263,505.0 1,263,505.0 /нэг сая хоёр зуун жаран гурван мянга таван зуун тав/ төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2021 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Солонгосын Политехник Коллежийн захирал Ц.Ганчимэг, ахлах нягтлан бодогч П.Пүрэвдорж нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТОР  
"АМГАЛАН АХУЙ АУДИТ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Г.ТҮВШИНЗАЯА  
Д.АМГАЛАН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig\_Kherreg\Akt\2021\0225auditin 2-R Газар29.Docx

001090471



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2021 оны 02 дугаар сарын 25

№ 36/АДН00-17

Улаанбаатар хот

САГ-2021/311/СТД-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Монгол Солонгосын политехник коллежийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Элсэгчдээс авдаг "Бүртгэлийн хураамж"-ийн 5,960,000.0 төгрөгийн орлогыг санхүүгийн тайланд тусгаагүй зарцуулсан байна. Үүнээс баримтаар нотлогдохгүй 163,000.0 төгрөгийн зарцуулалт байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 6 дугаар зүйлийн 6.3.1-д "төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Баримтаар нотлогдохгүй зарцуулалт хийсэн 163,000.0 төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2021 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Солонгосын Политехник Коллежийн захирал Ц.Ганчимэг, ахлах нягтлан бодогч П.Пүрэвдорж нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР


АУДИТОР

"АМГАЛАН АХУЙ АУДИТ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

Г.ТҮВШИНЗАЯА

Д.АМГАЛАН







ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2021 оны 02 дугаар сарын 25

№ 37/АДНОО17

Улаанбаатар хот

САГ-2021/311/СТД-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Монгол Солонгосын политехник коллежийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Зарим ажиллагсдын цалингаас 740,350.0 төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг суутгаагүй олгосон байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7.1 “Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлогыг хамруулна” ... үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого” болон 14.1-д “Энэ хуулийн 7.1-д заасан цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо уг орлогоос эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд төлсөн шимтгэлийг хасна” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Хувь хүний орлогын албан татвар суутган тооцоогүй 740,349.5 төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2021 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Солонгосын Политехник Коллежийн захирал Ц.Ганчимэг, ахлах нягтлан бодогч П.Пүрэвдорж нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТОР  
“АМГАЛАН АХУЙ АУДИТ” ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Б.ТҮВШИНЗАЯА  
Д.АМГАЛАН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 91/А0170077

Улаанбаатар хот

СДГ - 2021/311/СГА - ТШЗ  
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Монгол Солонгосын политехник коллежийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шүүхийн шийдвэрээр ажлаас үндэслэлгүй чөлөөлөгдсөн нэр бүхий 2 ажилтанд ажилгүй байсан хугацааны нөхөн олговор болох 24,111,970.0 /хорин дөрвөн сая нэг зуун арван нэгэн мянга есөн зуун дал/ төгрөгийг байгууллагаас олгосон байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн, 103.1-д "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ", гэж заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шүүхийн шийдвэрээр ажлаас үндэслэлгүйгээр халагдсан нэр бүхий 2 ажилтанд олгосон 24,111,970.0 /хорин дөрвөн сая нэг зуун арван нэгэн мянга есөн зуун дал/ төгрөгийн төрд учруулсан хохирлыг буруутай албан тушаалтнаар төлүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2021 оны 09 дүгээр сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Солонгосын политехник коллежийн захирал Ц.Ганчимэг, ахлах нягтлан бодогч П.Пүрэвдорж нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

Аудитын хоёрдугаар газрын захирал  
тэргүүлэх аудитор  
Аудитор

"АМГАЛАН АХУЙ АУДИТ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Г.ТҮВШИНЗАЯА

Д.АМГАЛАН





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 02/АД170011

Улаанбаатар хот

САГ-2021/311/СТА-ТШЗ  
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Монгол Солонгосын политехник коллежийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллага тайланд онд шилэн дансны цахим хуудсанд байршуулах 114 мэдээллээс 41 мэдээлэл хугацаа хоцроож, 5 сая төгрөгөөс дээш худалдан авалтын 246,514,870.0 төгрөгийн 15 мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, 6 дугаар зүйлийн 6.4 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ .... таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг” гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хууль тогтоомжийг, мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 09 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Солонгосын Политехник Коллежийн захирал Ц.Ганчимэг, ахлах нягтлан бодогч П.Пүрэвдорж нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТОР  
“АМГАЛАН АХУЙ АУДИТ” ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Г.ТҮВШИНЗАЯА  
Д.АМГАЛАН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 93/Д040077

Улаанбаатар хот

САГ-2021/31/СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Монгол Солонгосын политехник коллежийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Оюутнууд танхимаар хичээллээгүй хугацаанд хичээл үйлдвэрлэлийн дадлагад зориулагдсан 18,875,150.0 төгрөгийг тусгай зориулалтын материалаас зарцуулсан байна.


Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.1.1-д “нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах” Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулж, зөрчлийг арилгаж, биелэлтийг 2021 оны 09 дүгээр сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Солонгосын политехник коллежийн захирал Ц.Ганчимэг, ахлах нягтлан бодогч П.Пүрэвдорж нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТОР  
“АМГАЛАН АХУЙ АУДИТ” ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
Г.ТҮВШИНЗАЯА  
Д.АМГАЛАН





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 94/А0170077

Улаанбаатар хот

САГ-2021/311/СТД-ТШЗ  
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Монгол Солонгосын политехник коллежийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, алдаа зөрчлийг давтан гаргасан байна. Тухайлбал "Оюутны байрны төлбөр"-ийг багш ажилчдаас бэлнээр авдаг зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-т "аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх," гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, зөрчлийг арилган, биелэлтийг 2021 оны 09 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Солонгосын политехник коллежийн захирал Ц.Ганчимэг, ахлах нягтлан бодогч П.Пүрэвдорж нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

Аудитын хоёрдугаар газрын захирал  
тэргүүлэх аудитор  
Аудитор

"АМГАЛАН АХУЙ АУДИТ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
Г.ТҮВШИНЗАЯА

Д.АМГАЛАН





